



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/126

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", 29.2 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жил бүрийн намар төл малд хийгддэг бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг хийж гүйцэтгэх, зохион байгуулах ажлын хэсгийг доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: П.Аюушжав-(Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч)

Нарийн бичгийн дарга:(Р.Даваасүрэн-Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч эмч)

Гишүүд: Б.Батбилэгт-"Хустын рашаан" (Мал эмнэлгийн эзэн)

П.Содномбалжир-"Хутагт уулын өгөөж"(Мал эмнэлгийн эзэн)

С.Төмөр-(3 дугаар багийн Засаг дарга)

Л.Балжинням-(5 дугаар багийн Засаг дарга)

Г.Пүрэвтогтох-(4 дүгээр багийн Засаг дарга)

Д.Бямбасүрэн-(2 дугаар багийн Засаг дарга)

Ж.Нямтогтох-(1 дүгээр багийн Засаг дарга)

Г.Сугар-(Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

2. Төл малыг вакцинжуулах намрын ажлыг 2022 оны 08 дугаар сарын 27-оос 09 дүгээр сарын 10-ийг дуусталх хугацаанд хийж гүйцэтгэж, дүн мэдээг тухай бүр Засаг даргад танилцуулахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж (Хустын рашаан Хутагт-Уулын өгөөж)-нэгжүүдэд даалгасугай.

3. Вакцинжуулалтын ажлын зарыг малчдад хүргэж товлосон газарт мал сүргийг бэлэн байлгах ажлыг зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт тогтоосон хугацаанд вакцинжуулалтын арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулахыг мал бүхий иргэн, малчдад үүрэг болгосугай.

4. Вакцинжуулалтын ажлын явц, технологийн мөрдөлт, зохион байгуулалт, мал сүргийн хамрагдалтанд, байнгын хяналт тавин ажиллаж, гарсан зөрчил, дутагдлыг арилгуулж, хариуцлага тооцон ажиллахыг эрх бүхий улсын байцаагч (П.Аюушжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

622202259